

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Т.МӨНХСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 6 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж хуульчилсан бөгөөд иргэдэд үзүүлэх эмнэлгийн төлбөргүй тусламжийн болзол, журмыг хуулиар тогтоохоор заасан. Энэхүү үндсэн эрхийг бодитой хангах нь төрийн үндсэн үүргийн нэг төдийгүй үндэсний аюулгүй байдал, хүний хөгжил, нийгмийн хамгааллын бодлоготой салшгүй холбогдоно.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.11-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулахаар, мөн 2.2.12-т төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлд тулгуурлан хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй, “үйлчлүүлэгч төвтэй” эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжихээр тус тус заасан байна.

Уг бодлогын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээ, эрүүл мэндийн технологийг нэвтрүүлэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, даатгалын тогтолцоог хөгжүүлэх, дижитал эрүүл мэнд болон үндэсний эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг сайжруулах, анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байдаг.

Үүний дагуу Эрүүл мэндийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрүүл мэндийн байгууллагын засаглалын бие даасан байдлыг бэхжүүлэх, удирдах албан тушаалд томилогдох шалгуур, шаардлагыг Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон түүний

харьяа эрүүл мэндийн байгууллагын хариуцлагын тогтолцоог тодорхой болгох шаардлага үүссэн байна. Түүнчлэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалыг тусламж, үйлчилгээнд тавигдах шаардлага, санхүүжилтийн үр ашигтай уялдуулан оновчтой тогтоох, эрүүл мэндийн байгууллагын төрөл, чиг үүргийг үзүүлэх тусламж, үйлчилгээний чиглэлтэй нь нийцүүлэн тодорхойлох эрх зүйн хэрэгцээ бий болсон.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, орон нутгийн эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулах зорилтыг тусгасан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах асуудлыг тусгайлан тусгасан байна.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”, “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” зэрэг олон улсын бодлогын баримт бичгүүд нь эрүүл мэндийн тогтолцоог хүний эрхэд суурилсан, тэгш хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалсан, тогтвортой хэлбэрээр хөгжүүлэх шаардлагыг дэвшүүлж байна.

Иймд Монгол Улсын эрүүл мэндийн салбарын суурь зохицуулалтыг орчин үеийн эрүүл мэндийн тогтолцооны үзэл баримтлал, үндэсний хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх хууль зүйн шаардлага бий болжээ.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль нь 2011 онд батлагдсанаас хойш нийт 31 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүний үр дүнд хуулийн бүтэц, зохицуулалтын уялдаа холбоо, системчлэл алдагдаж, салбарын суурь хуулийн шинж чанар сул болсон байна. Одоогийн хүчин төгөлдөр зохицуулалт нь эрүүл мэндийн тогтолцоо, бодлого, санхүүжилт, засаглалын асуудлыг цогцоор нь тодорхойлохоос илүүтэйгээр эмнэлгийн байгууллагын төрөл, тусгай зөвшөөрөл, дотоод зохион байгуулалт зэрэг салангид асуудлыг түлхүү зохицуулсан шинжтэй болсон байна. Үүний улмаас Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зэрэг салбарын бусад хуулиудтай чиг үүргийн давхардал, зохицуулалтын хийдэл үүсэж, хууль хоорондын уялдаа хангалтгүй болсон.

Түүнчлэн хүчин төгөлдөр хуулуудиаар эрүүл мэндийн салбарын олон чухал харилцааг захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулахаар өргөн хүрээнд шилжүүлсэн нь хуулиас давсан журам бий болох, бүртгэлгүй журам хэрэгжих, журам хоорондын зөрчил үүсэх, иргэн болон хуулийн этгээдийн эрх зүйн тодорхой байдал алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчны тогтвортой байдал, хэрэгжилтийн нэгдмэл байдалд сөргөөр нөлөөлөх болсон.

Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг тогтолцооны түвшинд авч үзвэл, нэгдүгээрт, эрүүл мэндийн тогтолцооны нэгдмэл байдал сул байна. Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, эм зүйн тусламж, санхүүжилт, хүний нөөц, мэдээллийн тогтолцоо хоорондын уялдаа хангалтгүй, бодлого болон хэрэгжилтийн түвшинд салангид байдал үүссэн хэвээр байна. Эрүүл мэндийн тогтолцоо нь “эмнэлэг төвтэй” хэв шинжээ хадгалсан бөгөөд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого хангалттай хөгжөөгүй байна.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн засаглал, удирдлагын тогтолцоо сул хэвээр байна. Төрийн өмчит эмнэлгүүдийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтолцоо бодитой хэрэгжихгүй, эмнэлгийн удирдлагын томилгоонд улс төрийн нөлөөлөл өндөр байгаа нь байгууллагын бие даасан байдал, хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна. Мөн төв болон орон нутгийн удирдлагын чиг үүргийн зааг тодорхой бус, институт хоорондын зохицуулалт хангалтгүй байна.

Гуравдугаарт, эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо тогтворгүй байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдал нэмэгдэж, иргэдийн халааснаас гарах шууд зардал олон улсын зөвлөмжөөс өндөр түвшинд хүрсэн нь өрхийн санхүүгийн дарамтыг нэмэгдүүлж байна. Санхүүжилтийн бүтэц нь урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээнээс илүү эмчилгээ төвтэй хэвээр байгаа нь салбарын урт хугацааны тогтвортой байдалд эрсдэл үүсгэж байна.

Дөрөвдүгээрт, эм зүйн тусламж, үйлчилгээний тогтолцоо хангалтгүй байна. Эмийн хангамж, эмийн үнэ, хүртээмжийн асуудал зах зээлийн зохицуулалтад хэт тулгуурласан хэвээр байгаа бөгөөд эм зүйн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салшгүй хэсэг гэж бүрэн хүлээн зөвшөөрөөгүй байна. Үүний улмаас эмийн зохистой хэрэглээ, эмийн аюулгүй байдал, үнийн зохицуулалтын асуудал хангалтгүй түвшинд байна.

Тавдугаарт, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлого тогтвортой бус байна. Хүний нөөцийн хуваарилалт тэнцвэргүй, хөдөө орон нутагт эмнэлгийн мэргэжилтний дутагдал хэвээр байгаа бөгөөд ажлын ачаалал, стресс, нийгмийн баталгааны асуудал нь тусламж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Мөн хүний нөөцийн урт хугацааны төлөвлөлт, хэрэгцээнд суурилсан бодлого хангалтгүй байна.

Зургаадугаарт, дижитал эрүүл мэндийн эрх зүйн орчин хангалтгүй байна. Телемедицин, эрүүл мэндийн мэдээллийн сан, хиймэл оюун ухаанд суурилсан технологи, эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлыг зохицуулах суурь эрх зүйн орчин бүрэн төлөвшөөгүй бөгөөд салбарын цахим шилжилт бодлогын түвшинд нэгдсэн зохицуулалтгүй байна.

Долоодугаарт, эрүүл мэндийн тогтолцооны тэсвэртэй байдал хангалтгүй байна. Цар тахал, гамшиг, онцгой нөхцөл байдал зэрэг эрсдэлийн үед эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдал, нөөц, зохион байгуулалт хангалтгүй байгаа нь тогтолцооны эмзэг байдлыг илэрхийлсэн.

Иймд эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг хэсэгчилсэн байдлаар бус, тогтолцооны түвшинд шинэчлэн боловсронгуй болгож, эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт, санхүүжилт, хүний нөөц, технологи, мэдээлэл, хяналтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх шаардлага үүссэн байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төслийн зорилго нь иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах үндсэн эрхийг хангах хүрээнд эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, эрүүл мэндийн тогтолцооны суурь зарчим, бүтэц, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөц, дижитал эрүүл мэнд, инновац, салбар дундын хамтын ажиллагаа болон хяналтын харилцааг нэгдмэл байдлаар зохицуулахад оршино.

Хуулийн төсөл нь эрүүл мэндийн тогтолцоог зөвхөн өвчин эмчлэхэд чиглэсэн “эмнэлэг төвтэй” загвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эрсдэлийг бууруулахад чиглэсэн “нийгмийн эрүүл мэнд төвтэй” тогтолцоо руу үе шаттайгаар шилжүүлэх суурь эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэнэ. Түүнчлэн бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг хангах, иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээний улмаас үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаалах, нотолгоонд суурилсан бодлого, төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, эрүүл мэндийн салбарын дижитал шилжилт, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, эрүүл мэндийн тогтолцооны тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн суурь зохицуулалтыг тусгасан.

Мөн эрүүл мэндийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд болох нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, эм зүйн тусламж, санхүүжилт, хүний нөөц, эрүүл мэндийн мэдээлэл, технологи болон засаглалын тогтолцоог харилцан уялдаатайгаар төлөвлөж, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилготой болно.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 9 бүлгээр боловсруулагдах бөгөөд эрүүл мэндийн тогтолцооны суурь зохицуулалтыг нэгдмэл байдлаар тодорхойлоход чиглэсэн бүтэцтэй болно.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, эрүүл мэндийн хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, нэр томъёоны тодорхойлолт, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон эрүүл мэндийн тогтолцоонд баримтлах үндсэн зарчмыг тусгана. Энэ хүрээнд эрүүл мэндийн тогтолцооны хүний эрхэд суурилсан, тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй, нотолгоонд суурилсан, нэгдмэл байх суурь зарчмуудыг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн тогтолцооны нэгдмэл байдал, тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг, бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хүний нөөц, мэдээлэл, технологи болон эрүүл мэндийн тогтолцооны тэсвэртэй байдлыг харилцан уялдаатайгаар зохион байгуулах эрх зүйн үндсийг тусгана. Мөн эрүүл

мэндийн тусламж, үйлчилгээний тэгш хүртээмж, тогтолцоонд суурилсан үнэлгээ, төлөвлөлтийн асуудлыг зохицуулна.

Гуравдугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, төрийн байгууллагуудын бүрэн эрх, чиг үүрэг, хариуцлага, салбарын засаглалын тогтолцоог тодорхойлно. Энэ хүрээнд төрийн төв болон орон нутгийн байгууллагын эрх хэмжээ, эрүүл мэндийн байгууллагын удирдлага, төлөөлөн удирдах зөвлөлийн тогтолцоо, салбар дундын хамтын ажиллагааны механизмыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эм зүйн тусламж, үйлчилгээний төрөл, тогтолцоо, уялдаа холбоо, чиг үүргийг тодорхойлно. Түүнчлэн урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эрт илрүүлэх, сэргээн засах болон хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэр, эрүүл мэндийн даатгал, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, стратегийн худалдан авалтын тогтолцоо болон иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зохицуулалтыг тусгана. Мөн эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашиг, тогтвортой байдлыг хангах суурь механизмыг тодорхойлно.

Зургаадугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, бэлтгэл, мэргэжлийн хөгжил, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгаа, хамгааллын асуудлыг зохицуулна. Үүнд орон нутгийн хүний нөөцийн бодлого, тасралтгүй сургалт, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн ажилтны эрх зүйн хамгаалалтын асуудлыг хамруулна.

Долоодугаар бүлэгт дижитал эрүүл мэнд, эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо, телемедицин, эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, инноваци, эрүүл мэндийн технологийн үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулна. Энэ хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан, цахим шилжилт, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн хэрэглээ, мэдээллийн хамгаалалтын суурь зохицуулалтыг тусгана.

Наймдугаар бүлэгт иргэн, гэр бүл, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг зохицуулсан бөгөөд эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд олон талын оролцоог хангах эрх зүйн үндсийг тодорхойлно.

Есдүгээр бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хэрэгжүүлэхтэй холбоотой шилжилтийн зохицуулалт болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг зохицуулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн эрүүл мэндийн тогтолцооны нэгдмэл байдал бэхжинэ. Эрүүл мэндийн салбарын бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хүний нөөц, мэдээлэл, технологи болон тусламж, үйлчилгээний уялдаа холбоо сайжирснаар иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, чанар дээшлэх нөхцөл бүрдэнэ.

Мөн нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх бөгөөд эрт илрүүлэг, эрсдэлийн үнэлгээ, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа тогтолцооны түвшинд бэхжинэ. Үүний үр дүнд хүн амын эрүүл амьдралын хэв маяг төлөвших, халдварт болон халдварт бус өвчний эрсдэл буурах, эрүүл мэндийн боловсрол, хариуцлага дээшлэх эерэг үр нөлөө бий болно.

Түүнчлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, тасралтгүй байдлыг хангах тогтолцоо сайжирч, орон нутаг болон алслагдсан бүсийн иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртэх боломж нэмэгдэнэ. Дижитал эрүүл мэнд, телемедициний зохицуулалт боловсронгуй болсноор орон зайн хязгаарлалтаас үл хамааран төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээг иргэдэд хүргэх боломж өргөжинө.

Хуулийн төсөл батлагдсанаар эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог илүү тогтвортой, үр ашигтай хэлбэрээр хөгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ. Эрүүл мэндийн даатгал, улсын төсөв, орон нутгийн төсөв болон бусад санхүүжилтийн эх үүсвэрийн уялдаа сайжирснаар санхүүжилтийн үр ашиг нэмэгдэж, иргэдийн халааснаас гарах шууд зардлыг бууруулах боломж бүрдэнэ. Ингэснээр өрхийн санхүүгийн дарамт буурч, иргэд эрүүл мэндийн үйлчилгээний улмаас ядууралд өртөх эрсдэл багасна.

Мөн эрүүл мэндийн технологийн үнэлгээ, хүн амын хэрэгцээний шинжилгээнд суурилсан төлөвлөлт, хөрөнгө оруулалт, стратегийн худалдан авалтын тогтолцоо хөгжсөнөөр төсвийн зарцуулалтын үр ашиг дээшилж, шаардлагагүй зардал, давхардал буурах нөхцөл бүрдэнэ. Урьдчилан сэргийлэх бодлогыг дэмжсэн санхүүжилтийн тогтолцоо хөгжсөнөөр өвчлөлийн хүндрэл, эмчилгээний өндөр зардлыг бууруулах урт хугацааны эдийн засгийн эерэг үр нөлөө бий болно.

Түүнчлэн дижитал эрүүл мэнд, телемедицин, мэдээллийн нэгдсэн тогтолцоо хөгжсөнөөр эрүүл мэндийн үйлчилгээний зардал, цаг хугацааны алдагдал буурч, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг нэмэгдэнэ.

Эрүүл мэндийн салбарын суурь харилцааг тогтолцооны түвшинд шинээр тодорхойлсноор чиг үүргийн давхардал, эрх зүйн хийдэл арилж, салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирна. Эрүүл мэндийн тухай хууль нь салбарын бодлого, тогтолцоо, засаглал, санхүүжилтийн суурь зохицуулалтыг тодорхойлсон

суурь хууль болж, бусад дагалдах салбар хуулиудын зохицуулалтын хүрээ, зааг илүү тодорхой болно.

Мөн өмнө нь захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж ирсэн олон харилцааг хуулийн түвшинд тодорхой болгосноор эрх зүйн тодорхой байдал, хууль хэрэгжилтийн нэгдмэл байдал сайжирч, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийн хүрээ илүү ойлгомжтой болно. Үүний зэрэгцээ эрүүл мэндийн байгууллага, төрийн байгууллага, эрүүл мэндийн ажилтны эрх хэмжээ, хариуцлагын тогтолцоо тодорхой болж, засаглал, ил тод байдал, хариуцлагын механизм бэхжинэ.

Түүнчлэн дижитал эрүүл мэнд, телемедицин, эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, эрүүл мэндийн технологийн үнэлгээ зэрэг шинэ төрлийн харилцааг хуулиар зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрүүл мэндийн салбарын цаашдын хөгжлийн суурь нөхцөл бүрдэх юм.

Дөрөв. Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийн хүрээнд эрүүл мэндийн салбарын суурь тогтолцоо, бодлого, санхүүжилт, хүний нөөц, дижитал эрүүл мэнд, эм зүйн тусламж, үйлчилгээ болон эрүүл мэндийн мэдээллийн зохицуулалттай холбоотой харилцааг шинэчлэн тодорхойлж байгаатай холбогдуулан зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүснэ.

Тухайлбал, эрүүл мэндийн санхүүжилт, стратегийн худалдан авалт, даатгалын тогтолцооны шинэчлэлтэй уялдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Мөн эмнэлгийн байгууллагын бүтэц, төрөл, тусгай зөвшөөрөл, удирдлага, зохион байгуулалттай холбоотой зохицуулалтыг салбарчилсан байдлаар тодорхой болгох зорилгоор Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд холбогдох өөрчлөлтийг тусгана.

Эм зүйн тусламж, үйлчилгээ, эмийн үнэ, хүртээмж, эрүүл мэндийн технологийн үнэлгээ, нэгдсэн худалдан авалтын тогтолцоотой холбоотой шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Түүнчлэн нийгмийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх бодлого, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны зохицуулалтыг шинэчлэн тодорхойлохтой холбогдуулан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд холбогдох өөрчлөлт хийгдэнэ.

Мөн эрүүл мэндийн салбарын тусгай сан, санхүүжилтийн зохицуулалттай холбоотойгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд, эрүүл мэндийн мэдээллийн сан, дижитал эрүүл мэнд, телемедицин, хүний эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалттай холбоотойгоор Хүний хувийн

мэдээлэл хамгаалах тухай хуульд, түүнчлэн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, үйл ажиллагааны зохицуулалттай холбоотойгоор Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болно.

Ийнхүү Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирч, салбарын эрх зүйн зохицуулалт илүү нэгдмэл, тогтвортой, хэрэгжих боломжтой болох нөхцөл бүрдэх юм.

---oOo---